



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2023 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх" аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-эрдэнэ, Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд (Ч.Хүрэлбаатар), Сангийн сайд (Б.Жавхлан) нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Наранчимэг)-д даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын Аудитын удирдлагын менежер (Л.Мөнхцацрал)-д үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



## АГУУЛГА

<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....</b>	<b>4</b>
<b>НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....</b>	<b>7</b>
<b>Монгол Улсын 2024 оны макро эдийн засаг ба төсвийн бодлого, төлөвлөлтийн талаарх ерөнхий нөхцөл байдал .....</b>	<b>7</b>
<b>ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БҮРЭН УЯЛДААГҮЙ БАЙНА. ....</b>	<b>8</b>
<b>Төсвийн төсөл нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхой бус, эрх зүйн зохицуулалтгүй байна. ...</b>	<b>9</b>
<b>ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРААС УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГАСАН БОЛОВЧ 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛД НИЙЦЭХГҮЙ БАЙНА. ....</b>	<b>11</b>
<b>Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангасан байна. ....</b>	<b>12</b>
<b>Төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсвийн төсөлд нийцүүлэн өөрчилдөг зөрчлийг арилгах албан шаардлага хэрэгжээгүй байна. ....</b>	<b>13</b>
<b>ДӨРӨВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, УУЛ УУРХАЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫГ ХЭМЖЭЭГ ӨӨДРӨГӨӨР ТӨСӨӨЛСӨН БОЛОВЧ ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨЛЛӨӨС ШАЛТГААЛЖ ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА. ....</b>	<b>15</b>
<b>ТАВ. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ ҮР ДҮНД СУУРИЛСАН АРГА АРГАЧЛАЛААР БОЛОВСРУУЛСАН Ч ЗАРЛАГЫН ӨСӨЛТ БОЛОН ГАРЦЫН ӨСӨЛТИЙН УЯЛДАА ТОДОРХОЙГҮЙ, ИРГЭДИЙН БОДИТ ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙГААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА. ....</b>	<b>17</b>
<b>ЗУРГАА. ТӨСВИЙН ТӨСӨЛД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТАХ-НИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДЛЫН БОЛОН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. ....</b>	<b>22</b>
<b>ДОЛОО. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЛИЙГ ДНБ-НД ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦАА ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАЖ БАЙНА. ....</b>	<b>30</b>
<b>ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 74.0 ХУВЬ БАЙНА .....</b>	<b>33</b>
<b>ДҮГНЭЛТ: .....</b>	<b>34</b>
<b>ЗӨВЛӨМЖ: .....</b>	<b>35</b>
<b>ХАВСРАЛТУУД: .....</b>	<b>39</b>



<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b>
<b>Аудитын зорилго</b>	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/03 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.</p>
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	<p>Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэх доорх асуултад хариулт өгөхөд аудитын зорилго чиглэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>➢ Төсвийн төсөл нь улсын тогтвортой хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;</li><li>➢ Төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;</li><li>➢ Төсвийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэн, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;</li><li>➢ Төсвийн урсгал зарлагыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх;</li><li>➢ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, ач холбогдлоор эрэмбэлж, хууль болон эдийн засгийн үр өгөөжтэй байх шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;</li><li>➢ Төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдлыг нөхөх өрийн хэмжээг тогтоохдоо тусгай шаардлага хууль тогтоомжид нийцүүлж боловсруулсан эсэх;</li><li>➢ Төсвийн төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцож, хуулийн шаардлагад нийцүүлж төлөвлөсөн эсэх.</li></ul> <p>Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.</p>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	<p>Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.</p> <p>Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 6.9-д заасан шаардлагыг гол шалгуур болголоо.</p> <p>Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв /улсын төсөв, орон нутгийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан, бусад тусгай сангууд/-ийн 2024 оны төсвийн төсөл, 2021, 2022, 2023 оны батлагдсан</p>



<p><b>Талуудын хүлээх үүрэг, хариуцлага</b></p>	<p>төсөв, төсвийн гүйцэтгэл /батлагдсан болон урьдчилсан/, төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэв.</p> <p>Мөн аудитад Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.</p>
<p><b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b></p>	<p>Засгийн газар улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, танилцуулгын хамт Төсвийн тухай хуулийн 8.4-т заасан цаглабарын дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.</p> <p>Төрийн аудитын байгууллага Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг төрөөс баримтлах хөгжлийн болон мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах үүрэг хүлээнэ.</p> <p>Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал хэрэгжүүлж, аудитын менежер Х.Баярмаа, аудитын удирдлагын менежер Б.Болормаа, менежер Ц.Хосжаргал, Д.Отгонбаяр, П.Чанцалдулам, С.Нацагдорж, ахлах аудитор Э.Энхбаатар, Б.Сандуйжав, А.Даваадорж, Л.Нямтөмөр, В.Эрдэнэцогт, шинжээч Б.Ариунжаргал, аудитор Ү.Төгсжаргал, Б.Баясгалан, Б.Мөнхтуяа, М.Сангижанцан нар гүйцэтгэв.</p>



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОАЖС	БАЙГАЛ, ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
БСҮХД	БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА
БХБС	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД
БХС	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД
БШУС	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
ЗГХЭГД	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
ЗТХС	ЗАМ, ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН САЙД
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
МУ	МОНГОЛ УЛС
МУЕС	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
МУШС	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
НДС	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН
ОН	ОРОН НУТАГ
ОНБТСҮХД	ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА
ОУ	ОЛОН УЛС
САС	САНГИЙН САЙД
СОС	СОЁЛЫН САЙД
ТАХ	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ТӨХХК	ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
УЕП	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ХЗДХС	ХУУЛЬ, ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙД
ХНХС	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
ХХААХҮС	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
ЦХХХС	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД
ЦДАШ	ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ
ШЕЗ	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
ЭЗХЯ	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭМДС	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН
ЭМС	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ЭХС	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД



## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### **Монгол Улсын 2024 оны макро эдийн засаг ба төсвийн бодлого, төлөвлөлтийн талаарх ерөнхий нөхцөл байдал**

1.1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд төсөвт төвлөрүүлэх тэнцвэржүүлсэн орлогыг 20,781.9 тэрбум, төсвийн зарлагыг 22,371.4 тэрбум, тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,589.5 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталжээ.

1.2. Нэгдсэн төсвийн 2023 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 14,609.0 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 12,790.8 тэрбум, тэнцвэржүүлсэн тэнцэл 1,818.2 тэрбум төгрөгийн үр дүнтэй байна.

1.3. Монгол Улс цар тахлын хүндрэлийг даван туулж, 2023 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засаг 6.4 хувиар өсөж, нүүрсний экспорт эрчимжиж, тээвэр, худалдааны салбарын нийт борлуулалт, үйлдвэрлэл тэлж, гадаад валютын нөөц нэмэгдсэн зэрэг эерэг үзүүлэлттэй байна<sup>1</sup>.

1.4. Мөн нэрлэсэн ДНБ 30,500.0 тэрбум төгрөгт хүрч, 2022 оноос 30.6 хувиар, мөнгөний нийлүүлэлт 32,000.0 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 7.7 хувиар тус тус өссөн, инфляцын түвшин 2023 оны 8 дугаар сарын байдлаар 10.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буурсан боловч хөдөлмөрийн зах зээл, цар тахлаас өмнөх түвшинд хүрээгүй, ажилгүйдлийн түвшин 5.8 хувьтай байна<sup>2</sup>.

1.5. Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 21,163.2 тэрбум, нийт зарлагын дээд хэмжээг 22,996.1 тэрбум, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,832.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан байна.

1.6. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төслийг боловсруулахад үндэслэл болгосон Эдийн засаг, хөгжлийн яамны макро эдийн засгийн төлөв байдлын төсөөллөөр эдийн засгийг 7.0 хувиар өсөхөөр, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс нэрлэсэн ДНБ-ийг 13,060.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 74,000.0 тэрбум төгрөг, гадаад худалдааны эргэлтийг 2.8 тэрбум ам.доллараар өсгөж 25.4 тэрбум ам.доллар, экспортын голлох нэрийн бүтээгдэхүүн болох чулуун нүүрсний борлуулалтын хэмжээг 10.0 сая тонноор нэмэгдүүлж 60.0 сая тонн байхаар тус тус тооцсон байна.

1.7. Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад 21 хууль, УИХ-ын 7 тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулахаар УИХ-д өргөн мэдүүлжээ.

1.8. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 25,289.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.2 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 27,360.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.0 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,070.8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.8 хувь байхаар төлөвлөжээ.

1.9. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай” хуулиар тогтоосон тэнцвэржүүлсэн орлогыг 4,126.6 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 4,364.4 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцлийн

<sup>1</sup> Эх сурвалж: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

<sup>2</sup> Эх сурвалж: ЭЗХЯ-ны Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй гүйцэтгэл



алдагдлыг 237.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн барьсан байна.

1.10. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх бодлогыг баримталж, дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах;
- Хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- Уул уурхайн орлогоос орон нутгийн хөгжлийн санд нэмэлт орлого хуваарилах;
- Орон нутгийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих;
- Орон нутгийг орон сууцжуулах;
- Орон нутагт төрийн албан хаагчдын тогтвортой ажиллаж, амьдрах боломжоор хангах;
- Орон нутагт бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх;

## **ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БҮРЭН УЯЛДААГҮЙ БАЙНА**

2.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3<sup>3</sup>-т Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг улсын төсөв, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр болон таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн батлахаар заасан байна.

2.2. Монгол Улс 2023 онд тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн индексээр 3 байр урагшилсан боловч “тэгш бус байдлыг бууруулах”, “уур амьсгалын өөрчлөлт”-ийн зорилтын хэрэгжилт хангалтгүйгээс сүүлийн таван жилийн хугацаанд 14 байр ухарч, 2030 он гэхэд зорилтот түвшинд хүрэхгүй байх эрсдэлийг дагуулж байна.

2.3. Төсвийн төслийг боловсруулахдаа орлогын тэгш бус байдал, хот хөдөөгийн хөгжлийн, боловсролын хүртээмжийн ялгаатай байдлыг арилгах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийн бэрхшээлтэй болон ядууралд өртсөн иргэдийн тулгамдаж буй асуудлыг арилгахад чиглүүлэх шаардлагатай байна.

2.4. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тулгуур бүрэлдэхүүн болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан боловч Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд бүрэн тусгаагүй байна.

2.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, бүс орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах үүргийг Эдийн засаг, хөгжлийн яам хэрэгжүүлэх хуулийн зохицуулалттай боловч төсвийн төслийг стратеги төлөвлөгөө, хөгжлийн төлөвлөгөөтэй хэрхэн уялдуулж, тооцож, төлөвлөх талаар журам, аргачлал байхгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.

2.6. ТЕЗ нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй агуулгаараа нийцэж байна.

2.7. УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-д 6 багц асуудлын хүрээнд 29 зорилт, 97 үйл ажиллагаа, хүрэх үр дүнг тодорхойлж, хөгжлийн 20 төслийг

<sup>3</sup> Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6-д заасан баримт бичигт нийцүүлэн батлах



хэрэгжүүлэхээр баталснаас ТЕЗ нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний жагсаалтад 17-г тусгаагүй, 9-г хэрэгжүүлэхээр, 3-г хэсэгчлэн гүйцэтгэхээр тусгасан байна.

2.8. УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 6 бодлого, 23 ерөнхий хөтөлбөр тусгагдсанаас 2024 оны төсөвт ТЕЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 13-г бүрэн, 9-г агуулгын хувьд хэсэгчлэн гүйцэтгэх санхүүжилтийг тусгасан байна.

## **ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГОД НИЙЦҮҮЛЖ БОЛОВСРУУЛАХ, САЛБАР ХООРОНДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЯЛДАА ХАНГАЛТГҮЙ, ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА**

***Төсвийн төсөл нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхой бус, эрх зүйн зохицуулалтгүй байна.***

2.9. Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.1.1-д тус тус заасны дагуу тухайн оны төсвийн төсөл нь ... улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг хянаж, дүгнэлт өгөх эрх зүйн зохицуулалттай.

2.10. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан Эдийн засгийн аюулгүй байдалд хамаарах дараах бодлогын хэрэгжилт хангалтгүй, төсвийн төсөлд тусгасан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэхээр тусгасан хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлт Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.44 дэх хэсэгт заасан аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эсэх нь тодорхойгүйгээс иж бүрэн дүгнэлт өгөх боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал:

### ***Эдийн засгийн аюулгүй байдал***

- *Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого – “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална...” гэж заасан хэдий ч сүүлийн 5 жилийн байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын 36.7-60.4 хувь Канад улс, хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 35.4-46.1 хувь Нидерланд улсад ногдож байна.*
- *“Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ” гэж заасан боловч энэ талаар 2024 оны төсвийн бодлогод тодорхой тусгаагүй, үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь оролцоог тооцож, үнэлэх боломжгүй, албан ёсны статистик тоо, мэдээлэл байхгүй байна.*
- *Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг төрийн аль нэг байгууллагад даалгаагүй, хянаж, үнэлэх тогтолцоо бүрдээгүй байна.*
- *Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал – “Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана ...” гэж заасан*

<sup>4</sup> Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.Үндэсний аюулгүй байдал нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

- 3.4.1.Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;
- 3.4.2.нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;
- 3.4.3.иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;
- 3.4.4.эдийн засгийн аюулгүй байдал;
- 3.4.5.шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;
- 3.4.6.мэдээллийн аюулгүй байдал;
- 3.4.7.монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;
- 3.4.8.хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;
- 3.4.9.экологийн аюулгүй байдал.
- 3.4.10.хүнсний аюулгүй байдал.





хэдий ч Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2023 оны 08 дугаар сарын байдлаар 3,933.3 сая ам.доллар байгаа нь валютын төлбөртэй барааны импортын жилийн дундаж гүйцэтгэлээр тооцоход 5.3 сар буюу 22.7 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд байна.

#### **Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого**

- “... Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана” гэж заасан боловч 2020 онд 1,684.9 сая кВт эрчим хүчийг импортолж, нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ нэмэгдэхийн хэрээр, гадаадаас импортлох эрчим хүчний хэмжээ сүүлийн 5 жил тогтмол өсөж, 2,107.4 сая кВт хүрсэн байна.
- “Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана...” гэж заасан хэдий ч Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 108 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах” төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн үйлдвэрийн бүтээн байгуулалт 2027 онд дуусахаар байгаа нь 2024 онд дотоодын үйлдвэрээс газрын тосны хэрэгцээг хангах нөхцөлгүй болгож байна.

2.11. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлоготой нийцүүлсэн байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийг 53.0 хувьтай гэж үнэлжээ.

2.12. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан хүчин төгөлдөр мөрдөж буй Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг олон улсад хэрэгжүүлж буй арга, туршлагатай харьцуулахад бодлогын хүрээ хязгаарлагдмал, эдийн засгийн аюулгүй байдлын зарим үзүүлэлт тусгагдаагүй байна.

2.13. Эдийн засгийн аюулгүй байдлын гол шалгуур нь амьдралын чанарыг дээшлүүлэх эдийн засгийн тогтвортой, эрчимтэй хөгжлийг хангах асуудал бөгөөд энэ хүрээнд зайлшгүй харгалзан үзэх 9 үзүүлэлтээс Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд далд эдийн засаг, дэлхийн эдийн засагт эзэлж буй хувийн жин, хүн амын амьдралын чанар, ажилгүйдлийн түвшин, төсвийн алдагдал зэрэг 5 үзүүлэлтийг тусгаагүй байна.

2.14. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д хуулийн төслийн агуулга “... үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх” гэж заасан хэдий ч уг хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд төсвийн төсөл үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг үнэлэх шалгуургүй байгаад өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.



## ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРААС УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГАСАН БОЛОВЧ 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛД НИЙЦЭХГҮЙ БАЙНА

3.1. Эдийн засаг, хөгжлийн яам нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3-т заасны дагуу макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөллийг тооцож Сангийн яаманд хүргүүлснийг 2024 оны нэгдсэн төсвийн төслийг боловсруулахад үндэслэл болгосон байна.

Хүснэгт 1. Макро эдийн засгийн төсөөлөл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 оны ХБГ	2024 оны төс.	Өсөлтийн хувь 2023/2024
Нэрлэсэн ДНБ	тэрбум төгрөг	37,453	43,555	53,851	60,940	74,000	21.4
Бодит ДНБ, (2015 оны үнээр)	тэрбум төгрөг	26,655	27,091	28,455	30,150	32,250	7.0
Эдийн засгийн өсөлт, хувь	хувиар	(4.6)	1.6	5.0	6.0	7.0	16.9
Инфляц /жилийн дундаж/	хувиар	3.7	7.3	15.2	10.4	8.5	(18.3)

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

3.2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг тооцсон эх сурвалжуудын зарим статистик үзүүлэлт, тоо дүн зөрүүтэй байна. Тухайлбал Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд ДНБ-ийг 74,000.0 тэрбум, Монголбанкнаас УИХ-д өргөн барьсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд 71,500.0 тэрбум, аудитаар ДНБ-ийг статистик мэдээлэл дээр үндэслэн тооцоход 72,130.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцоологдсон байна.

3.3. Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д төсвийн төсөл “төрийн мөнгөний бодлогын зорилтод нийцсэн байх” гэж заасан хэдий ч УИХ-аас “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг эцэслэн батлаагүй, Монголбанк төслийг 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн байна.

3.4. Монголбанкнаас “улс төр болон уур амьсгалын тодорхой бус байдлаас 2024 онд дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй, эрдэс түүхий эдийн эрэлт, үнэ буурах, улмаар урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэх, төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс тасрах эрсдэлтэй бөгөөд 2023 онд тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин, зарим төрлийн халамж үйлчилгээний зардлыг өсгөсөн Засгийн газрын шийдвэр нь 2024 оны инфляц, мөнгөний бодлогод сөргөөр нөлөөлөх үр дагавартай байна”<sup>5</sup> гэж дүгнэсэн байна.



3.5. Монгол Улсын нэгдсэн төсвийн зардал, ДНБ-ий хамаарлыг олон хүчин зүйлсээс хамааруулан загварчлахад нийгмийн сайн сайхан байдлыг хангах, эдийн засагт бодит өсөлтийг дэмжихэд нэгдсэн төсвийн нийт зарлага нь тухайн оны ДНБ-ий 30.0 хувь буюу 2024 онд 22,200.0 тэрбум төгрөгөөр тогтоох нь оновчтой байна. Харин нэгдсэн төсвийн төслийн 2024 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 27,360.5 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх хувь 36.9 хувь байгаа нь загварчлалаар тооцсон оновчтой хэмжээнээс 6.9 хувь буюу 5,160.5 тэрбум төгрөгөөр илүү байна.

<sup>5</sup> Эх сурвалж: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанк



**Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангасан байна**

Хүснэгт 2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага	Төсвийн төсөлд тусгасан байдал	Тусгай шаардлага хангасан байдал																												
1	6 дугаар зүйлийн 6.1.1-т "нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх"	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2024 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,386.6 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 182.5 ам.доллар байхаар тооцсон байна.	<p>Зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тус хуулийн 11.1.3.а-д заасны дагуу зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,386.6 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 182.5 ам.доллар байхаар тооцсон байна.</p>  <table border="1"> <caption>Тэнцвэржүүлсэн орлого /Их.наяд төг/</caption> <thead> <tr> <th>Үйлдвэр</th> <th>2020 гүйц</th> <th>2021 гүйц</th> <th>2022 гүйц</th> <th>2023 тод</th> <th>2024 төс</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Зэс</td> <td>9.5</td> <td>12.7</td> <td>17.1</td> <td>20.8</td> <td>25.3</td> </tr> </tbody> </table>	Үйлдвэр	2020 гүйц	2021 гүйц	2022 гүйц	2023 тод	2024 төс	Зэс	9.5	12.7	17.1	20.8	25.3																
Үйлдвэр	2020 гүйц	2021 гүйц	2022 гүйц	2023 тод	2024 төс																										
Зэс	9.5	12.7	17.1	20.8	25.3																										
2	6 дугаар зүйлийн 6.1.2. нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх, 19 дүгээр зүйлийн 19.9-т... 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй	Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,070.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -2.8 хувьтай тэнцэхээр төлөвлөсөн байна.	<p>МУ-ын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд ДНБ-ийг 74,000.0 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөжээ. Төсвийн алдагдал -2,070.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -2.8 хувьтай тэнцэж байна.</p>  <table border="1"> <caption>ДНБ /Их наяд төгрөг/</caption> <thead> <tr> <th>Үйлдвэр</th> <th>2020 гүй</th> <th>2021 гүй</th> <th>2022 гүй</th> <th>2023 тод</th> <th>2024 төс</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>ДНБ</td> <td>36.96</td> <td>42.13</td> <td>53.51</td> <td>60.19</td> <td>74.00</td> </tr> </tbody> </table> <table border="1"> <caption>Тэнцвэржүүлсэн тэнцэл /Тэрбум төгрөг/</caption> <thead> <tr> <th>Үйлдвэр</th> <th>2018 гүй</th> <th>2019 гүй</th> <th>2020 гүй</th> <th>2021 гүй</th> <th>2022 гүй</th> <th>2023 тод</th> <th>2024 төс</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Тэнцэл</td> <td>-</td> <td>-756.2</td> <td>4,440.4</td> <td>2,919.0</td> <td>1,032.7</td> <td>1,589.5</td> <td>-2,070.8</td> </tr> </tbody> </table>	Үйлдвэр	2020 гүй	2021 гүй	2022 гүй	2023 тод	2024 төс	ДНБ	36.96	42.13	53.51	60.19	74.00	Үйлдвэр	2018 гүй	2019 гүй	2020 гүй	2021 гүй	2022 гүй	2023 тод	2024 төс	Тэнцэл	-	-756.2	4,440.4	2,919.0	1,032.7	1,589.5	-2,070.8
Үйлдвэр	2020 гүй	2021 гүй	2022 гүй	2023 тод	2024 төс																										
ДНБ	36.96	42.13	53.51	60.19	74.00																										
Үйлдвэр	2018 гүй	2019 гүй	2020 гүй	2021 гүй	2022 гүй	2023 тод	2024 төс																								
Тэнцэл	-	-756.2	4,440.4	2,919.0	1,032.7	1,589.5	-2,070.8																								



3	<p>6 дугаар зүйлийн 6.1.3. тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;</p>	<p>Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 22.5 хувьтай, 2012-2023 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 12.9 хувьтай тус тус тэнцэж байна. 2024 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 22.3 хувь байхаар тусгасан байна.</p>	<p>Нэгдсэн төсвийн нийт зарлагыг 2024 онд 27,360.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2023 оны тодотголтой харьцуулахад 22.3 хувиар нэмэгдүүлсэн байна. Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 22.5 хувьтай, мөн 2012-2023 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 12.9 хувьтай байна.</p> <p>Эрдэс баялгийн бус ДНБ (их наяд төгрөг)</p> <table border="1"> <thead> <tr> <th>Он</th> <th>Өсөлт (%)</th> </tr> </thead> <tbody> <tr><td>2009</td><td>5.0</td></tr> <tr><td>2010</td><td>7.7</td></tr> <tr><td>2011</td><td>10.6</td></tr> <tr><td>2012</td><td>13.0</td></tr> <tr><td>2013</td><td>16.3</td></tr> <tr><td>2014</td><td>18.6</td></tr> <tr><td>2015</td><td>19.2</td></tr> <tr><td>2016</td><td>19.1</td></tr> <tr><td>2017</td><td>21.3</td></tr> <tr><td>2018</td><td>24.7</td></tr> <tr><td>2019</td><td>28.2</td></tr> <tr><td>2020</td><td>28.7</td></tr> <tr><td>2021</td><td>32.5</td></tr> <tr><td>2022</td><td>40.0</td></tr> <tr><td>2023</td><td>44.4</td></tr> <tr><td>2024</td><td>54.4</td></tr> <tr><td>2025</td><td>54.4</td></tr> <tr><td>2026</td><td>54.4</td></tr> </tbody> </table> <p>Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж</p> <table border="1"> <thead> <tr> <th>Он</th> <th>Өсөлт (%)</th> </tr> </thead> <tbody> <tr><td>2012</td><td>31.1</td></tr> <tr><td>2013</td><td>17.1</td></tr> <tr><td>2014</td><td>19.7</td></tr> <tr><td>2015</td><td>3.4</td></tr> <tr><td>2016</td><td>-0.4</td></tr> <tr><td>2017</td><td>11.5</td></tr> <tr><td>2018</td><td>15.8</td></tr> <tr><td>2019</td><td>14.4</td></tr> <tr><td>2020</td><td>1.7</td></tr> <tr><td>2021</td><td>14.3</td></tr> <tr><td>2022</td><td>21.9</td></tr> <tr><td>2023</td><td>14.0</td></tr> <tr><td>2024</td><td>12.9</td></tr> </tbody> </table>	Он	Өсөлт (%)	2009	5.0	2010	7.7	2011	10.6	2012	13.0	2013	16.3	2014	18.6	2015	19.2	2016	19.1	2017	21.3	2018	24.7	2019	28.2	2020	28.7	2021	32.5	2022	40.0	2023	44.4	2024	54.4	2025	54.4	2026	54.4	Он	Өсөлт (%)	2012	31.1	2013	17.1	2014	19.7	2015	3.4	2016	-0.4	2017	11.5	2018	15.8	2019	14.4	2020	1.7	2021	14.3	2022	21.9	2023	14.0	2024	12.9
Он	Өсөлт (%)																																																																				
2009	5.0																																																																				
2010	7.7																																																																				
2011	10.6																																																																				
2012	13.0																																																																				
2013	16.3																																																																				
2014	18.6																																																																				
2015	19.2																																																																				
2016	19.1																																																																				
2017	21.3																																																																				
2018	24.7																																																																				
2019	28.2																																																																				
2020	28.7																																																																				
2021	32.5																																																																				
2022	40.0																																																																				
2023	44.4																																																																				
2024	54.4																																																																				
2025	54.4																																																																				
2026	54.4																																																																				
Он	Өсөлт (%)																																																																				
2012	31.1																																																																				
2013	17.1																																																																				
2014	19.7																																																																				
2015	3.4																																																																				
2016	-0.4																																																																				
2017	11.5																																																																				
2018	15.8																																																																				
2019	14.4																																																																				
2020	1.7																																																																				
2021	14.3																																																																				
2022	21.9																																																																				
2023	14.0																																																																				
2024	12.9																																																																				
4	<p>6 дугаар зүйлийн 6.1.4. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.</p>	<p>Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ 70,455.0<sup>6</sup> тэрбум төгрөгтэй харьцуулсан харьцаа нь 42.7 хувьд хүрэх төлөвтэй байна.</p>	<p>Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 30,099.3 тэрбум төгрөг буюу ДНБ 74,000.0 тэрбум төгрөгтэй харьцуулсан харьцаа нь 40.7 хувь байна.</p> <p>Засгийн газрын өр /2021-2024 он/</p> <table border="1"> <thead> <tr> <th>Он</th> <th>ЗГ-ын өр (ӨҮЦ)/ДНБ (%)</th> <th>Хуулийн хязгаар (%)</th> </tr> </thead> <tbody> <tr><td>2021</td><td>50.8</td><td>70.0</td></tr> <tr><td>2022</td><td>52.4</td><td>70.0</td></tr> <tr><td>2023</td><td>44.3</td><td>65.0</td></tr> <tr><td>2024</td><td>40.7</td><td>60.0</td></tr> </tbody> </table>	Он	ЗГ-ын өр (ӨҮЦ)/ДНБ (%)	Хуулийн хязгаар (%)	2021	50.8	70.0	2022	52.4	70.0	2023	44.3	65.0	2024	40.7	60.0																																																			
Он	ЗГ-ын өр (ӨҮЦ)/ДНБ (%)	Хуулийн хязгаар (%)																																																																			
2021	50.8	70.0																																																																			
2022	52.4	70.0																																																																			
2023	44.3	65.0																																																																			
2024	40.7	60.0																																																																			

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний аудитын газар

**Төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсвийн төсөлд нийцүүлэн өөрчилдөг зөрчлийг арилгах албан шаардлага хэрэгжээгүй байна**

3.6. Монгол Улсын тухайн жилийн нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд нийцүүлсэн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуулиар тус тус зохицуулдаг.

<sup>6</sup> Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийг төсөв боловсруулах үед ЭЗХЯ-аас хүргүүлсэн ДНБ 70,455.0 тэрбум төгрөгтэй харьцуулсан байна.



3.7. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль анх баталснаас хойш 14 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд тодорхой заалтуудын хэрэгжилтийг удаа дараа хойшлуулсан байна.

3.8. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлтэй хамт 2023 оны 5 дугаар 31-ний өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Үүнд:

- *Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 4,126.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж;*
- *Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 4,364.4 тэрбум төгрөгөөр;*
- *Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээг 2,468.4 тэрбум төгрөгөөр;*
- *Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг 320.0 тэрбум төгрөгөөр;*
- *Засгийн газрын өрийн нийт хэмжээг өнөөгийн үнэ цэнээр 5,124.0 тэрбум төгрөгөөр,*
- *Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээг 235.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж;*
- *Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 237.9 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.*

3.9. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ”, 7.4-т “Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүйгээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах, батлах болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхгүйгээр төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

3.10. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх бус төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсөвтөө тааруулан өөрчилж байгаа асуудалд өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

3.11. УИХ-аас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-ийг боловсруулахдаа нүүрсний экспортын биет хэмжээг 50.0 сая тонн, эдийн засгийн өсөлтийг 6.5 хувь байхаар төсөөлсөн боловч 2023 оны эцэст экспортын хэмжээ эрчимжиж, эдийн засаг сэргэх төлөв ажиглагдсан тул Засгийн газраас ирэх жил “Боомтын сэргэлт”-ийн зорилтыг хэрэгжүүлснээр нүүрсний экспортын биет хэмжээг 60.0 сая тонн, эдийн засгийн өсөлтийг 7.0 хувьд хүрэхээр шинэчлэн тооцож, төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх хуулийн төсөл боловсруулсан байна.

3.12. Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулснаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зорилт хангагдахгүй байх, ач холбогдол буурах, төсвийн удирдлагын зарчим, сахилга бат алдагдаж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг үндэслэлгүй боловсруулах эрсдэл үүсэж байна.




## ДӨРӨВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, УУЛ УУРХАЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫГ ХЭМЖЭЭГ ӨӨДРӨГӨӨР ТӨСӨӨЛСӨН БОЛОВЧ ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨЛЛӨӨС ШАЛТГААЛЖ ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА

4.1. Монгол Улсын 2024 оны нийт орлого ба тусламжийн дүнг 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4,242.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 27,156.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнд: татварын орлогыг 23,436.1 тэрбум, татварын бус орлогыг 1,853.7 тэрбум төгрөгөөр төлөвлөж, Тогтворжуулалтын санд 513.7 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 1,353.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

4.2. Засгийн газраас 2023 онд эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлснээр гол нэрийн эрдэс баялгийн экспортын хэмжээ Ковид-19 цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрч, нүүрсний экспортын хэмжээ хүлээгдэж буй гүйцэтгэлээр 52.0 сая тонн болж төлөвлөснөөс 4.0 хувиар давахаар байна.

4.3. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд экспортын гол нэр төрлийн зарим эрдэс баялгийн бүтээгдэхүүний биет хэмжээг дараах байдлаар төлөвлөсөн байна.

Дүрслэл 1. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, сая тонн



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.4. Төсвийн төсөлд тусгасан экспортод гаргах 60.0 сая тонн нүүрсний 50 хувийг буюу 30.0 сая тонн нүүрсийг Эрдэнэс Тавантолгой ХК экспортлохоор төлөвлөсөн бөгөөд тус компани 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 20.6 сая тонн нүүрсийг экспортод гаргасан байна.

4.5. Төмрийн хүдрийн 2023 онд экспортлох хэмжээг 6.9 сая тонн гэж төлөвлөсөн боловч БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын эрэлт буурснаас эхний 8 сарын бодит гүйцэтгэлээр 3.6 сая тонн төмрийн хүдрийг экспортод гаргасан байна.

4.6. Төсвийн төсөлд 2024 онд экспортлох төмрийн хүдрийн биет хэмжээг 8.4 сая тонноор (1 тонн тутамд 75 ам.доллар) байхаар тооцсон нь төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна.

4.7. Төсвийн нийт орлогын 29.5 хувь буюу 8,001.2 тэрбум төгрөгийг уул уурхайн салбарын татварын орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 4,513.5 тэрбум төгрөг, аж ахуйн нэгж орлогын албан татвараас 1,919.4 тэрбум төгрөг, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн ногдол ашгаас 546.6 тэрбум төгрөг, 1,021.9 тэрбум төгрөгийг бусад татвар, төлбөр хураамжаар төвлөрүүлэхээр тооцсон байна.

4.8. Төсвийн нийт орлого болон ДНБ-ий хамаарлыг квадрат экспоненциал өсөлтийн загвараар тооцоолоход төсвийн орлого 2024 онд хамгийн ихдээ 25,344.0 тэрбум төгрөг байх боломжтой байна. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт орлогыг 27,156.8 тэрбум төгрөгөөр буюу боломжит хязгаараас 1,812.8 тэрбум төгрөгөөр илүү, хэт өөдрөгөөр төсөвлөсөн нь БНХАУ-ын эдийн засгийн сэргэлтийн удаашрал, үл хөдлөх, аж үйлдвэрийн салбарт ашиглагдах түүхий эдийн эрэлт, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах



зээлийн үнэ буурах зэрэг гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр төсвийн орлого тасалдах эрсдэлтэй байна.


4.9. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд татварын орлогыг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 3,454.8 тэрбум төгрөгөөр буюу 17.3 хувиар нэмж төлөвлөсөн байна.

4.10. Орлогын албан татварыг 32.4 хувь, нийгмийн даатгалын орлогыг 26.5 хувь, нэмэгдсэн өртгийн албан татварыг 25.5 хувиар, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын буцаалтыг 43.8 хувь, хувь хүний орлогын албан татварын буцаалтыг 30.8 хувь, бусад татвар, төлбөр хураамжийн орлогыг 17.3 хувиар тус тус нэмэгдүүлэн тооцож төлөвлөжээ.

4.11. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлж боловсруулаагүй, төсвийн орлогыг нэмэгдүүлэхээр баримталсан бодлого нь хэт ерөнхий, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүй, бодлогын зорилт хангагдахгүй байх эрсдэлтэй, төсвийн орлогыг нарийвчлан тооцох аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

4.12. 2024 оны төсвийн төсөлд татварын ачааллыг 31.7 хувь байхаар тооцсон бөгөөд жил ирэх тусам өсөж байгаа нь татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр татварын хамрагдалт, татварын бааз суурийг өргөжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Дүрслэл 2. Татварын ачаалал




Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.13. 2024 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөлтөөр татварын ачаалал 31.7 хувь, 2015-2022 оны гүйцэтгэлээр 20.7-29.2 хувь байгаа нь өнгөрсөн жилүүдийн гүйцэтгэлийн хамгийн их утгаас 2.5 пунктээр өндөр байна.

4.14. Татварын бус орлогын дүнг 2023 оны тодотголоор баталсан дүнгээс 0.7 хувиар бууруулж 1,853.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь газрын тосны орлогыг 14.8 хувь, хүү, торгуулийн орлогыг 10.3 хувиар тус тус бууруулж тооцсонтой холбоотой байна.

4.15. Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүнд эзлэх татварын бус орлогын дүн 2023 оны тодотголын дүнгээс 1.7 пунктээр буурчээ.

Дүрслэл 3. Татварын болон татварын бус орлогын харьцаа



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл




### ТАВ. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ ҮР ДҮНД СУУРИЛСАН АРГА АРГАЧЛАЛААР БОЛОВСРУУЛСАН Ч ЗАРЛАГЫН ӨСӨЛТ БОЛОН ГАРЦЫН ӨСӨЛТИЙН УЯЛДАА ТОДОРХОЙГҮЙ, ИРГЭДИЙН БОДИТ ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙГААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

5.1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2023 оны тодотгосон төсвөөс 4,989.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 27,360.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнд: Урсгал зардалд 21,324.8 тэрбум, хөрөнгийн зардалд 6,170.4 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлд 134.7 тэрбум төгрөг зарцуулахаар тус тус төлөвлөсөн байна.


5.2. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 21,324.8 тэрбум төгрөгөөр тусгасан нь нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 77.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 4. Урсгал зардал /тэрбум төгрөг/




5.3. Урсгал зардал 2017-2022 оны гүйцэтгэлээр жилд дунджаар 14.7 хувийн өсөлттэй байгаа ба 2024 онд 2023 оны тодотгосон төсвөөс 26.1 хувийн өсөлттэй байхаар төлөвлөжээ.

Дүрслэл 5. ДНБ-ий болон урсгал зардлын өсөлтийн хувь



5.4. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төслийн урсгал зардлын өсөлт нь 26.1 хувь, ДНБ-ий 28.8 хувь буюу ДНБ-ий төсөөллийн өсөлтөөс 3.1 пунктээр өндөр байна.

Дүрслэл 6. Урсгал зардлын бүтэц /тэрбум төгрөг/




5.5. Урсгал зардлын бүтцийг авч үзвэл бараа үйлчилгээний зардал 41.9 хувь, зээлийн үйлчилгээний төлбөр 5.5 хувь, татаас урсгал шилжүүлэг 52.6 хувийг тус тус эзэлж байна.

5.6. Бараа үйлчилгээний зардалд цалин хөлс, шимтгэлийн зардал 68.3 хувийг голлон эзэлж байгаа нь 2023 оны тодотгосон төсвийн хэмжээнээс 9.7 пунктээр, 2017-2022 оны дундаж хэмжээнээс 9.2 пунктээр өндөр байна.





Дүрслэл 7. Бараа үйлчилгээний зардал, цалин хөлс, шимтгэлийн зардал /тэрбум төгрөг/



5.7. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн хамт 38 ТЕЗ нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна.

5.8. ТЕЗ нар 2024 онд нийт 103 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодорхойлжээ.

5.9. Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгосон боловч хөтөлбөрүүдийн өртөг, хөтөлбөр бүрийн дагуу үзүүлэх ажил, үйлчилгээ гарцыг илэрхийлээгүй, өөрөөр хэлбэл төлөвлөсөн зарлагын өсөлт бүрийг гарцын өсөлтөд харьцуулсан уялдааг тодорхой харуулаагүй байна.

**Иргэдийн бодит орлогыг хамгаалах арга хэмжээний хүрээнд төсөвлөсөн зардал нь инфляцыг өсгөх эрсдэл бий болгосон, урсгал зардалд 48.6 тэрбум төгрөгийн тэвчиж болох зардлыг бууруулах боломжтой байна.**

5.10. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд нийт урсгал зардал 21,324.8 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс улсын төсөвт 15,962.0 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 3,123.6 тэрбум төгрөг, НДС-ийн төсөвт 5,145.5 тэрбум төгрөг, ЭМДС-ийн төсөвт 1,970.6 тэрбум төгрөгийг тус тус тусгасан байна.

5.11. Улсын төсвийн 38 ТЕЗ нарын 15,962.0 тэрбум төгрөгийн урсгал зардлын 55.9 хувийг бараа үйлчилгээний зардал, 9.6 хувийг татаас, 34.5 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

5.12. Төсвийн төслийн нийт урсгал зардлын 47.1 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, 12.9 хувийг гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 15.0 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 16.0 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 6.0 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 3.0 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

5.13. Урсгал зардал өмнөх оны тодотгосон төсвөөс 4,410.7 тэрбум төгрөг буюу 26.0 хувиар өссөн нь Монгол Улсын 2024 оны төсвийн бодлогод туссан дараах хөтөлбөр, арга хэмжээтэй холбоотой байна. Үүнд:

- Иргэдийн бодит орлогыг хамгаалах багц арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2024 онд болох сонгуулийн арга хэмжээг санхүүжүүлэх;
- Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэх;
- Хүн амын өсөлт, үнэ тарифын өөрчлөлттэй холбоотой зардлыг санхүүжүүлэх.

5.14. Иргэдийн бодит орлогыг хамгаалах багц арга хэмжээний хүрээнд цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг 10.0 хувиар нэмэгдүүлэхэд 878.0 тэрбум төгрөг тусгасан байна.

5.15. УИХ-ын 2023 оны 39 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д 3.2.2-т “Үр дүнд суурилсан удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрэн нэвтрүүлэн, төрийн албаны бүтцийн шинэчлэлийг хийж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг ажлын бүтээмж, үр дүнтэй уялдуулан нэмэгдүүлнэ” гэж заасан ч 2024 оны төсвийн бодлогод төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх бөгөөд нийтлэг төрийн үйлчилгээ, хот тохижилт үйлчилгээний салбарын ажиллагсдын үндсэн цалинг 20.0 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10.0 хувь нэмэгдүүлэхээр тооцож төсвийн төсөлд тусгасан байна.



5.16. Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж, инфляцад нөлөөлөх нөлөөллийг бууруулах шаардлагатай байна.

5.17. Бусад бараа үйлчилгээний зардлаас дараах 48.6 тэрбум төгрөгийн тэвчиж болох зардлыг бууруулах боломжтой байна. Үүнд:

- Ноос, арьс ширний урамшуулал нь малчдын орлого болон тэдгээр түүхий эдээр хийсэн дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн хэмжээнд төдийлөн нөлөө үзүүлэхгүй байгаа ба үүнтэй холбоотойгоор бодлогын шинэчлэл хийгдээгүй байхад ноос, арьс ширний урамшуулалд 25.5 тэрбум төгрөгийг төсвийн хязгаараас хэтрүүлэн төсөвлөсөн;
- ХХААХҮС-ын төсвийн төсөлд тариалангийн талбайг хашаажуулах арга хэмжээний зардалд 6.5 тэрбум төгрөг төлөвлөсөн нь Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч дараах үүрэгтэй: 20.2.1.өөрийн эзэмшлийн талбай, ургацаа бусдын халдлага болон малаас хамгаалах” гэж заасантай нийцээгүй;
- Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээ болон эм, эмийн бэлдмэлийн зардлын төсөвлөлт нь Монгол Улсын нийт мал сүргийн тоонд харьцуулахад малын өөрийн өртөгтэй дүйцэхүйц ба төсвийн хязгаараас 13.1 тэрбум төгрөгөөр хэтрүүлсэн;
- Батлан хамгаалах сайдын бараа үйлчилгээний зардалд нэмэгдүүлсэн 3.5 тэрбум төгрөгийн зардал.

**Урсгал зардлын төсөвт 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг тусгаж төлөвлөсөн байна**

5.18. Төсвийн төслийн эд хогшил, урсгал засварын зардалд дараах хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг тусгасан байна.

**Хүснэгт 3. Урсгал зардалд төсөвлөсөн хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээ**

Д/д	Утга	ТЕЗ-ийн нэр	Төсөвт өртөг /тэрбум төгрөг/
1	Их засварын зардлыг урсгал зардлаар төсөвлөсөн	Боловсрол, шинжлэх ухааны сайд	0.4
2		Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	0.5
2		Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	0.2
4		Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	0.3
6	Тоног төхөөрөмжийн хөрөнгийн зардлыг Багаж, техник, хэрэгслийн ангилалд төсөвлөсөн	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	0.2
8		Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	1.1
9		Зам, тээврийн хөгжлийн сайд	0.3
14		Эрүүл мэндийн сайд	0.5
15		Эрчим хүчний сайд	0.1
<b>Нийт дүн</b>			<b>3.6</b>

Эх сурвалж: ТЕЗ-аас 2024 оны төсвийн төсөлд ирүүлсэн санал

5.19. Төсөв захирагчдын урсгал зардалд хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл арга хэмжээг төсөвлөсөн нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ирээдүйд үр өгөөж өгөх хөтөлбөр, зорилтын үр дүн, гарц буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

**2024 оны УИХ-ийн болон ОН-ийн ээлжит сонгуулийн зардлаас 0.1 тэрбум төгрөгийн зардлыг бууруулах боломжтой байна**

5.20. 2024 оны УИХ-ийн болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ийн ээлжит сонгууль болохтой холбогдуулан 2024 оны төсвийн төсөлд нийт 62.9 тэрбум төгрөгийн зардал төсөвлөсөн байна.



5.21. 2020 оны УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуульд зарцуулсан зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад 27.3 тэрбум төгрөгөөр буюу 76.8 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

5.22. Монгол Улсын Үндсэн хуулийн 2023 оны нэмэлт өөрчлөлтөөр Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна гэж заасны дагуу гишүүдийн тоо, сонгуулийн насны хүн амын тооны өсөлт, инфляцын нөлөөлөл зэргээс шалтгаалан 2024 оны УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуулийн зардлыг нэмэгдүүлж тооцжээ.

5.23. 2024 оны сонгуулийн зардлаас дараах зардлыг бууруулах боломжтой байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн “10.1.7-д сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээ, түүнд холбогдох тоног төхөөрөмж, ажил, үйлчилгээний зардал” гэж заасны дагуу 2024 оны ээлжит УИХ-ийн болон орон нутгийн ИТХ-ын сонгуулиар 910.8 сая төгрөг төсөвлөснөөс “Цахим хуудсанд баннер байрлуулах”, “Олон нийтийн сүлжээний цахим хуудас ашиглан сонгогчдод мэдээлэл хүргэх” 110.3 сая төгрөгийн зардлыг хэмнэх боломжтой байна.
- Мөн тус заалтын дагуу сонгогчдод сонгуулийн хууль тогтоомжийг тайлбарлан таниулах эрхзүйн мэдээлэл өгөх “Call center” ажиллуулах 22.0 сая төгрөгийн зардлыг тусгасан нь тооцоо судалгаа байхгүй байна.

**Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан төрийн албыг цомхон болгох зорилт хангагдаагүй байна**

5.24. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн тайлангаар төрийн албан хаагчийн тоо, төсвийн байгууллагын тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 4. Төрийн албан хаагчийн тоо хүн амын тооны харьцуулалт**


Д/д	Он	Хүн амын тоо	Төрийн албан хаагч /мянган/	Нийт хүн амд эзлэх хувь
1	2010	2,760,968	155.7	5.6%
2	2011	2,811,666	161.6	5.7%
3	2012	2,867,744	162.8	5.7%
4	2013	2,930,277	169.4	5.8%
5	2014	2,995,949	183.6	6.1%
6	2015	3,061,600	186.5	6.1%
7	2016	3,119,935	189.0	6.1%
8	2017	3,177,899	192.5	6.1%
9	2018	3,238,479	193.6	6.0%
10	2019	3,191,684	198.5	6.2%
11	2020	3,253,283	205.0	6.3%
12	2021	3,312,275	208.9	6.3%
13	2022	3,457,548	225.2	6.5%

Эх сурвалж: ТАЗ-ийн үйл ажиллагааны тайлан

5.25. Төрийн албан хаагчдын тоо жил дундаж өсөлт 3.0 хувийн, хүн амын тоотой харьцуулахад 0.2 хувийн өсөлттэй байна.



**Дүрслэл 6. Төрийн албан хаагчдын орон тооны динамик өсөлт**



5.26. Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт цомхон төрийн албатай байх гэсэн зорилт төрийн албан хаагчдын өсөлтөөс харахад хангагдаагүй байна.

5.27. Улсын төсвийн төсөлд 17 ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын орон тоог 2024 онд нийт 2387 орон тоог нэмэгдүүлэхээр тусгаж, түүнтэй холбоотой нийт 113.4 тэрбум төгрөгийн цалин хөлсний зардлыг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Эх сурвалж: ТАЗ-ийн үйл ажиллагааны тайлан

**Нийгмийн халамжийн сангийн зардлаас 5 болон түүнээс дээш төрлийн халамжийн үйлчилгээг авч байгаа 27.6 мянган хүн байна**

5.28. Нийгмийн халамжийн сангийн 2024 оны төсвийн төсөлд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 2,388.2 тэрбум төгрөгөөр тусгасан нь 2023 оны тодотголоос 180.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

5.29. Халамжийн сангаас 2023 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 268,478 хүн давхардсан байдлаар халамжийн үйлчилгээ авч байна. Үүний 77.8 хувь буюу 208,827 хүн 2-оос 3 нэр төрлийн халамжийн үйлчилгээг, 22.2 хувь буюу 59,651 хүн 4-өөс дээш нэр төрлийн халамжийн үйлчилгээг давхардуулан авч байна. Улсын хэмжээнд нэг хүн хамгийн өндөр буюу 19 нэр төрлийн халамжийн үйлчилгээг давхардуулан авдаг байна.

**Хүснэгт 5. Нийгмийн халамжийн төрөл /тэрбум төгрөг/**

Д/д	Нийгмийн халамжийн төрөл	2022 оны гүйцэтгэл		2023 оны тодотгосон төсөв		2024 оны төсвийн төсөл	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Халамжийн тэтгэвэр /сар бүр 325.0 мян төг/	65,615	182.9	65,615	244.6	67,615	284.8
2	Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох тэтгэмж /жилд нэг удаа 100.0-200.0 мян төг/	246,686	31.0	246,686	31.7	257,522	31.7
3	Асаргааны тэтгэмж /сар бүр 275.0 мян төг/	65,865	59.4	65,865	126.5	67,493	210.3
4	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж /2 төрөл - улсын төсвөөс/	58,583	46.0	58,583	56.6	60,724	84.5
5	Асрамжийн үйлчилгээ	127	0.5	127	0.5	127	0.5
6	Хүүхдийн мөнгө /хүүхэд бүрд сар бүр 100.0 мян төг/	-	-	1,278,516	1,534.2	1,302,385	1,562.9



7	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ /том хүн 16.0 мян, хүүхэд -8.0 мян төг/	121,958	20.0	121,958	22.8	121,958	22.8
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ	50,789	10.2	50,789	9.7	59,950	9.7
9	Ахмад настанд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтийн дүн	282,738	26.7	282,738	25.5	313,873	25.5
10	Насны хишиг /50.0-250.0 мян төг/	168,201	25.1	168,201	27.6	177,546	27.6
11	Цалинтай ээжийн дүн	205,645	98.0	205,645	116.9	205,831	116.9
12	Жирэмсэн эхийн тэтгэмж/төрөх хүртэл сар бүр 40.0 мян төг/	77,575	10.8	77,575	11.1	77,575	11.1

Эх сурвалж: ХНХС-ын 2024 оны төсвийн төсөлд ирүүлсэн санал

5.30. Нийгмийн халамжийн сангийн 65.4 хувийг хүүхдийн мөнгө эзэлж байна. 2024 оны төсвийн төсөлд 1,302,385 хүүхдэд 1,562.9 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байна. Хүүхдийн мөнгө 2023 оны тодотгосон төсвөөс 1.9 хувиар өссөн нь хүүхдийн тооны өсөлтөөс хамаарсан байна. Хүүхдийн мөнгө 2024 оны улсын төсвийн урсгал зардлын 9.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6. Хүүхдийн мөнгө

Нийгмийн халамжийн сан	2023	2024	Өсөлт хувиар	Улсын төсвийн урсгал зардалд эзлэх хувь
	Тод	Төсөл		
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,207.7	2,388.2	8.2	15.0
Хүүхдийн мөнгө	1,534.2	1,562.9	1.9	9.8

Эх сурвалж: ХНХС-ын 2024 оны төсвийн төсөлд ирүүлсэн санал

## ЗУРГАА. ТӨСВИЙН ТӨСӨЛД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТАХНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДЛЫН БОЛОН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

6.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 9,121.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1049 төсөл, арга хэмжээг 3,240.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна. Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл, /тэрбум төгрөг/

Ангилал	Шилжих ТАХ			Шинэ ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	506	4,560.3	1,444.6	358	3,531.2	1,232.9	864	8,091.5	2,677.6
Их засвар	23	76.6	35.4	18	50.3	45.2	41	126.9	80.6
Тоног төхөөрөмж	20	479.9	99.9	118	346.9	323.4	138	826.8	423.4
ТЭЗҮ	3	5.7	3.6	3	70.4	55.5	6	76.2	59.0
<b>Нийт</b>	<b>552</b>	<b>5,122.5</b>	<b>1,583.5</b>	<b>497</b>	<b>3,998.8</b>	<b>1,657.0</b>	<b>1049</b>	<b>9,121.4</b>	<b>3,240.6</b>

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээлэл



6.2. Төсвийн хөрөнгөөр 2024 онд эргэн төлөлт хийх концессын барих-шилжүүлэх төрлөөр “Дархан - Сэлэнгийн авто замаас Шаамар – Цагааннуур - Түшиг - Зэлтэрийн боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 120.8 км /Дархан-Уул, Сэлэнгэ/” ТАХ-г 25.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан байна.

6.3. Төсвийн хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, хувийн хэвшлийн бизнесийн орчныг дэмжих суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгасан нийт төсөл, арга хэмжээний 38.3 хувь нь дэд бүтцийн салбарт хэрэгжихээр төлөвлөсөн байна.

6.4. Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд нийт улсын төсвийн хөрөнгө оруулалтын 79.2 хувийг орон нутагт хэрэгжихээр төлөвлөжээ.


6.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төслийг төлөвлөхдөө дараах шинэчлэл хийсэн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тус бүрийг цахим системээс давтагдахгүйгээр коджуулсан;
- ТАХ-ний анхны төсөвт өртөг буюу анх төсөвт тусгахдаа ямар төсөвт өртгөөр эхэлж байсныг тусгасан нь ил тод нээлттэй байдлыг сайжруулсан;
- Сангийн яамны “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем-PIMIS”-д ТАХ-г төлөвлөж, холбогдох мэдээллийг бүрэн цахимжуулан, тухайн төсөлтэй холбоотой бусад мэдээллийг оруулах боломжтой болсон.

**Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 71.0 хувь нь улсын хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд тусгагдсан байна**

6.6. УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-д нийт 205 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг 13.9 их наяд төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг ангилан харуулбал:

Дүрслэл 8. ТАХ-ний санхүүжилтийн эх үүсвэр



Эх сурвалж: Сангийн яам

Дээрх мэдээллээс нийт эх үүсвэрийн 19 хувийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна. Тодруулбал: Улсын төсвөөс 2.1 их наяд төгрөгөөр 67 ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгажээ.

6.7. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3<sup>7</sup>-т заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг төсвийн төслийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хэрхэн туссаныг харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

<sup>7</sup> 6.10.3.улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;



Хүснэгт 8. Жилийн хөгжлийн төлөвлөгөөний ТАХ 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан байдал

МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын чиглэл	Тэргүүлэх чиглэл	ТЕЗ-ийн үр дүн	МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан ТАХ-ны тоо	2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгасан ТАХ	
				Тусгасан	Тусгаагүй
"Алсын хараа - 2050" - Эдийн засгийн бүлгийн хүрээнд	1. Экспортыг нэмэгдүүлнэ.	1.2. Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1	1	
	2. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	2.3. Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	8	8	
		2.4. Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	4	3	1
		2.5. Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна.	2	2	
"Алсын хараа-2050" - Хүний хөгжлийн бүлгийн хүрээнд	3. Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	3.1. Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.	9	9	
"Алсын хараа-2050" - Бүс, орон нутгийн хөгжил бүлгийн хүрээнд	4. Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	4.1. Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	1		1
		4.3. Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	23	13	10
"Алсын хараа-2050" - Бүс, орон нутгийн хөгжил бүлгийн хүрээнд	5. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	5.1. Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ.	2	1	1
"Алсын хараа-2050" - Улаанбаатар ба дагуул хот бүлгийн хүрээнд	6. Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	6.1. Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	6	6	
		6.2. Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	6	1	5
"Алсын хараа-2050" - Засаглалын бүлгийн хүрээнд	7. Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	7.2. Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.	1	1	
		7.3. Хүний эрхийн зөрчлийг бууруулна.	2	1	1
		7.5. Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ.	1	1	
<b>Нийт дүн</b>			<b>65</b>	<b>46</b>	<b>19</b>

Эх сурвалж: Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Сангийн яамнаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээлэл



6.8. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 19 төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд тусгаагүй байна. Үүнд:

- Зураг төсөв хийгдэхээр төлөвлөсөн боловч ажлын зураг төсөв эцэслэн боловсруулагдаагүй;
- Худалдан авах ажиллагаа удаа дараа амжилтгүй болсноос магадлалын хугацаа дууссан;
- Автозамын зарим төсөл, арга хэмжээг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, хэлэлцээрийн шатанд явж байгаа;
- ТЕЗ төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь дахин эрэмбэлж, харилцаа холбоогүй алслагдсан багуудыг холбоожуулах төслийг түрүүлж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

6.9. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 71.0 хувь нь 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тусгагдсан байна.

**Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг тусгасан байна**

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ

6.10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 497 төсөл, арга хэмжээнээс 358 нь барилга байгууламжийн ангилалд байна. Үүнээс 5.8 хувь буюу 21 төсөл, арга хэмжээний зураг, төсөл магадлалаар баталгаажих шатандаа, 43.0 хувь буюу 153 төсөл, арга хэмжээ иж бүрэн бус (нэг маяг болон жишиг) магадлалтай, холболтын зураг, төсөл нь хийгдэж байна. Ангилан харуулбал:

Хүснэгт 9. ТАХ-ний магадлалын мэдээлэл тоогоор/

ТЕЗ	Нийт ТАХ-ний тоо	Магадлалтай	Үүнээс	Нэг маягийн зураг, төслийг баталгаажуулсан магадлалтай <sup>8</sup> (Иж бүрэн бус магадлалтай)	Зураг төсөл магадлалаар баталгаажих шатанд байгаа
			Хугацаа дууссан магадлалтай		
БОАЖС	12	4		7	1
БСҮХД	1	1			
БХБС	33	24	2	6	3
БХС	1	1			
БШУС	111	38		72	1
МУЕС	1	1			
ЗГХЭГД	10	2		8	
ЗТХС	57	47	2	1	9
ОНБТСҮХД	16	3		12	1
CaC	1	1			
CoC	22	14	1	7	1
УЕП	1	1			
ХЗДХС	10	7		2	1
ХНХС	11	4		5	2
ХХААХҮС	9	1		7	1
ЦХХХС	5			5	
ШЕЗ	1	1			
МУШС	2	1		1	
ЭМС	29	9	2	20	
ЭХС	25	24			1

<sup>8</sup> Энэ ангилалд нэр, байршил нь өөр, барилга байгууламжийн хийц ойролцоо ТАХ-ний магадлалыг хавсаргасан ТАХ-үүд мөн багтсан.





Нийт	358	184	7	153	21
------	-----	-----	---	-----	----

Эх сурвалж: *pimis.publicinvestment.gov.mn* (Дэлгэрэнгүйг хавсралт 6-аас харна уу)

6.11. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1.2.2</sup><sup>9</sup>, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-т “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх” гэж заасантай нийцээгүй тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6.12. Нэг маягийн зураг төсөлтэй төсөл, арга хэмжээнд холболтын зураг төслийн төсөв нэмэгдэж, төсөвт өртөг нэмэгдэх, үүнээс ТАХ цаг хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

6.13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд өмнөх жилүүдэд хийсэн аудитаар хугацаандаа хэрэгжээгүй хойшлогдсон, төсөвт өртөг нэмэгдсэн, барилга байгууламж дуусгалгүй орхигдсон гол шалтгааны нэг нь магадлалгүй болон иж бүрэн бус магадлалтай зураг төсөлтэй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээс болсон байв.

6.14. Магадлалаар баталгаажсан зураг төсөлтэй зарим өндөр төсөвт өртөгтэй ТАХ-г үе шаттайгаар хэрэгжүүлэх, төсөвт өгөх ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс хэсэгчилсэн хуваарилалтыг хийсэн байна. Нийт дүнгээр харуулбал:

Хүснэгт 10. ТАХ-ний төсөвт өртөг, магадлалаар баталгаажсан төсөвт өртөгийн зөрүү /тэрбум төгрөг/

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Хуулийн төсөлд туссан төсөвт өртөг	Магадлалаар баталгаажсан төсөвт өртөг	Зөрүү
1	ЗТХС	14	431.1	2,241.9	1,810.8
2	ЭМС	2	15.4	104.4	89.0

Эх сурвалж: *pimis.publicinvestment.gov.mn*, Сангийн яамнаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээлэл (Дэлгэрэнгүйг хавсралт 6-аас харна уу)

Эдгээр ТАХ-ээс дурдвал:

**ЗТХС-ын багцад:**

- Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох хатуу хучилттай авто зам, 32.4 км /Ховд, Дарви сум/;
- Ерөө сумын төвөөс Бугант чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 27.8 км /Сэлэнгэ, Ерөө сум/;
- “Баруун-Урт - Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/” ТАХ-ний төсвийн төсөлд туссан төсөвт өртөг 11.1 тэрбум төгрөг, магадлалаар баталгаажсан төсөвт өртөг 68.9 тэрбум төгрөг,

**ЭМС-ын багцад:**

- “Зүрх, судасны үндэсний төвийн барилгын гадна инженерийн шугам, сүлжээ /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо/” ТАХ-ний төсвийн төсөлд туссан төсөвт өртөг 2.2 тэрбум төгрөг, магадлалаар баталгаажсан төсөвт өртөг 92.3 тэрбум төгрөг;

Энэ нь дараах асуудлаас шалтгаалсан байна. Тухайлбал:

- Зам тээврийн салбарын томоохон төслүүдийг төсвийн боломж, санхүүжүүлэх хэмжээндээ тулгуурлан хэсэгчлэн тусгасан;

<sup>9</sup> Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх.



- Эрүүл мэндийн салбарын томоохон үндэсний эмнэлгүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хувийн хэвшлийн эх үүсвэрийг татахын тулд улсын төсвөөс дэд бүтцийг хийх зэргээр ТАХ-ний төсөвт өртгийг хэсэгчлэн тусгасан байна.

6.15. Уг шалтгаан нөхцөлөөс харахад ТАХ-г хэсэгчлэн хэрэгжүүлэх тохиолдолд тухайн хэсгийн ажлын тоо хэмжээ, төсвийг гаргах шаардлага үүсэхээр байна.

6.16. Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1.1</sup>-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь ... эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна” гэж заасан ч 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцоолол хангалтгүй байна. Тодруулбал шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн ангиллын ТАХ-ний **82.4** хувь буюу **295**-д уг тооцооллыг хийгээгүй байна.

6.17. Мөн эдгээр ТАХ-ний үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцоолол хангалтгүй буюу **79.8** (286) хувь нь уг тооцооллыг хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг огт гаргаагүй байна. Ангилан харуулбал:

*Хүснэгт 11. ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцоолол, /тоогоор/*

ТЕЗ	ТАХ-ний тоо	Барилга байгууламжийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцсон эсэх		ТАХ-ний ашиглалтын зардлын тооцоолол хийсэн эсэх	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
БОАЖС	12		12		12
БСҮХД	1		1		1
БХБС	33	2	31	2	31
БХС	1		1		1
БШУС	111	4	107	10	101
ЕС	1	1		1	
ЗГХЭГД	10	1	9	1	9
ЗТХС	57	3	54	4	53
ОНБТСҮХД	16	1	15	2	14
СаС	1		1		1
СоС	22	12	10	12	10
УЕП	1	1		1	
ХЗДХС	10	4	6	4	6
ХНХС	11		11		11
ХХААХҮС	9	8	1	5	4
ЦХХХС	5		5	1	4
ШЕЗ	1	1		1	
ШС	2		2		2
ЭМС	29	2	27	4	25
ЭХС	25	23	2	24	1
<b>Нийт</b>	<b>358</b>	<b>63</b>	<b>295</b>	<b>72</b>	<b>286</b>

Эх сурвалж: [pimis.publicinvestment.gov.mn](http://pimis.publicinvestment.gov.mn), Сангийн яамнаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээлэл (Дэлгэрэнгүйг хавсралт 6-аас харна уу)



6.18. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2<sup>10</sup>, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.4<sup>11</sup>-г тус тус зөрчсөн байна.

6.19. 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-ний барилга байгууламжийн ангилалд шинээр хэрэгжүүлэхээр тусгагдсан зураг төсөл нь магадлалаар баталгаажих шатанд байгаа, иж бүрэн бус магадлалтай, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т нийцээгүй ТАХ-г төсвийн жил эхлэхээс өмнө холбогдох шаардлагад нийцүүлсэн байх албан шаардлагыг өгөв.

6.20. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд туссан зарим ТАХ тухайн ангилалд тохирохгүй байна. Тухайлбал:

- Монгол Улсын Ерөнхий сайдын багцад “Төрийн өмчийн удирдлагын мэдээллийн систем, дэд бүтэц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” ТАХ;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн багцад “Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь мэдээллийн систем, цөм систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/” ТАХ барилга байгууламжийн ангилалд тус тус туссан байна.

6.21. Энэ нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д ““барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг” гэж заасантай нийцэхгүй байна.

6.22. Цаашид олон улсын хөгжлийн чиг хандлагын дагуу цахимжуулалт эрчимтэй хөгжиж байгаатай холбогдуулан хөрөнгө оруулалтын ТАХ-ний ангилалд “биет бус хөрөнгө оруулалт” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна. Өөрөөр хэлбэл мэдээллийн систем, программ хангамжийг тусад нь ангилах нь зүйтэй байна.

6.23. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан 497 ТАХ-ний тухайн жилийн санхүүжих дүнг Төсвийн тухайн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож ... ” гэж заасан шаардлагыг хангасан эсэхийг тулгахад дараах байдалтай байна.

Хүснэгт 12. Төсөвт өртөгт эзлэх санхүүжилтийн хувь, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт			Тухайн жилд санхүүжүүлэх дүнгийн төсөвт өртөгт эзлэх хувь (доод хэмжээ)	Төсөвт өртөгт эзлэх санхүүжилтийн хувь
1 жилд хэрэгжүүлэх ТАХ	Тоо	168	100	100
	Төсөвт өртөг	484.1		
	Санхүүжих дүн	484.1		
2 жилд хэрэгжүүлэх ТАХ	Тоо	161	50	48.8
	Төсөвт өртөг	830.1		
	Санхүүжих дүн	405.5		
3 жилд хэрэгжүүлэх ТАХ	Тоо	168	33	28.5
	Төсөвт өртөг	2,684.6		
	Санхүүжих дүн	767.4		

Эх сурвалж: Үндэсний аудитын газар

6.24. Дээрх мэдээллээс харахад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д шаардлагыг хангахад чиглэсэн байна.

<sup>10</sup> Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна

<sup>11</sup> Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх.



Шилжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ

6.25. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд өмнөх оноос шилжин хэрэгжүүлэхээр 552 ТАХ тусгасан байна.

6.26. Эдгээр ТАХ-тэй “Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах” гүйцэтгэлийн аудитын хүрээнд төсөвт өртгийн нэмэгдлийн дүнг баталгаажуулсан 211 ТАХ-г тулгахад бүгд төсвийн төсөлд туссан байна. Ангилан харуулбал:

Хүснэгт 13. Аудитаар баталгаажуулсан ТАХ-ний төсөвт өртгийн дүн (тэрбум төгрөг)

Д/д	ТЕЗ	ТАХ-ний тоо	ТАХ-ний нийт төсөвт өртөг	
1	БОАЖС	2	9.9	Тус аудитаар нийт 16 ТЕЗ-д хамаарах 211 ТАХ-ний төсөвт өртгийг 1,811.4 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан байна.
2	БХБС	26	161.6	
3	БХС	2	14.5	
4	БШУС	88	466.0	
5	ЗТХС	6	267.2	
6	ЗГХЭГД	3	6.8	
7	ОНБТСҮХД	7	39.9	
8	МУШС	1	12.5	
9	СаС	2	18.1	
10	СоС	14	134.8	
11	УЕП	3	15.9	
12	ХЗДХС	6	8.1	
13	ХНХС	8	173.0	
14	ХХААХҮС	12	75.8	
15	ЭМС	25	99.5	
16	ЭХС	6	307.9	
<b>Нийт</b>		<b>211</b>	<b>1,811.4</b>	

Эх сурвалж: Аудитын дүгнэлт

6.27. Төсөл, арга хэмжээнд дахин магадлал хийж, төсөвт өртгийг нэмэгдүүлж байгаа нь дараах шалтгаантай байна.

- Худалдан авах ажиллагааг магадлалаар баталгаажсан зураг төсөвт үндэслээгүй, хэсэгчлэн зохион байгуулагдсан;
- Өртгийн тооцоо судалгаагүйгээр, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр тендер зарлаж, гэрээ байгуулсан бөгөөд зураг төсөл батлагдаж, магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөвт өртөг нэмэгдсэн;
- Баталгаажсан зураг төсөвгүй худалдан авах ажиллагаа зохион байгуулсан, гэрээ байгуулсны дараа магадлалын ерөнхий дүгнэлт баталгаажсан;
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн байршилд батлагдсан зураг төслийн ажлын тоо хэмжээг үндэслээгүй, өөр байршилд баригдах зургийг ашигласан
- Баталгаажсан магадлалын ерөнхий дүгнэлтээс бага дүнгээр төсөвт тусгаж, гэрээ байгуулсан;
- Захиалагч зураг төслийн иж бүрдэлгүй гүйцэтгэгч сонгон шалгаруулж, түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээ байгуулсан;
- Захиалагчийн хүсэлтээр төсөл арга хэмжээний байршлыг өөрчилсөн;
- Гадна инженерийн шугам сүлжээний ажлыг зураг төсөвт оруулалгүй орхисноос нэмж магадлал хийсэн;
- Магадлалаар баталгаажуулсан зураг төслийг үндэслээгүй, ажлын тоо хэмжээ нэмэгдсэн, зарим ажлыг хасаж тендер зарласан;



- Дутуу ажлуудын зураг төслүүдийг нэмж магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан;
- Техникийн нөхцөлийг өөрчилж хүчин чадлыг нэмэгдүүлсэн;
- Ажлын зурагт тусгагдсан төмөр бетон тулгуурыг өөрчлөх, мөн ЦДАШ-н трасс ашигт малтмалын лицензийн талбайтай давхцаж буйтай холбогдуулж зураг төсөл, төсөвт өөрчлөлт оруулсан;
- Ковид 19-н нөлөөллийн улмаас нэмэгдэл зардал гарсан.

6.28. Төсөвт өртгийн нэмэгдэл гарах болсон шалтгааны 79 хувь нь захиалагчаас, 15 хувь нь зураг төсвөөс, 6 хувь нь гүйцэтгэгчээс болсон байна. Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулахад барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх ажлыг зохион байгуулах, худалдан авах үйл ажиллагаа, гэрээ байгуулах, захиалагчийн гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, улсын комисс хүлээн авах үйл ажиллагааны үе шат бүрд дотоод хяналт хэрэгжүүлж, хүнээс хамаарсан нөлөөллийг бууруулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

6.29. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд бүртгэх боломжгүй, нийтийн эзэмшлийн талбай, тохижилтын төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгасан байна.

## ДОЛОО. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЛИЙГ ДНБ-Д ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦАА ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАЖ БАЙНА

7.1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдлийг нэрлэсэн дүнгээр 35,213.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дотоод үнэт цаас 3,089.6 тэрбум төгрөг, гадаад үнэт цаас 9,360.0 тэрбум төгрөг, гадаад зээл 22,209.0 тэрбум төгрөг, Засгийн газрын өрийн баталгаа 29.8 тэрбум төгрөг, барих-шилжүүлэх концессын эргэн төлөгдөх дүн 25.0 тэрбум төгрөг, орон нутгийн зээл 500.0 тэрбум төгрөг байхаар тусгасан байна.

Хүснэгт 14 14. Засгийн газрын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2021 он	2022 он	2023 он ХБГ	2024 оны төс	Зөрүү
<b>I.Засгийн газрын дотоод өр</b>	<b>657.3</b>	<b>1,035.5</b>	<b>1,064.2</b>	<b>3,089.6</b>	<b>2,025.4</b>
1.1 Үнэт цаас	657.3	1,035.5	1,064.2	3,089.6	2,025.4
<b>II. Засгийн газрын гадаад өр</b>	<b>24,693.3</b>	<b>29,641.6</b>	<b>30,601.5</b>	<b>31,569.0</b>	<b>967.5</b>
2.1 Үнэт цаас	8,175.6	9,359.8	9,248.8	9,360.0	111.2
2.2 Зээл	16,517.7	20,281.8	21,352.7	22,209.0	856.3
<b>III.Бусад өр</b>	<b>1,550.4</b>	<b>1,275.3</b>	<b>306.7</b>	<b>54.8</b>	<b>251.9</b>
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	876.5	811.8	30.7	29.8	-0.9
3.2 Барих-шилжүүлэх концесс	673.9	463.5	276.0	25.0	251.0
<b>IV.Орон нутгийн зээллэг</b>	<b>17.2</b>	<b>12.3</b>	<b>200.0</b>	<b>500.0</b>	<b>300.0</b>
4.1 Нийслэл	17.2	12.3	200.0	500.0	300.0
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР</b>	<b>26,918.2</b>	<b>31,964.7</b>	<b>32,172.4</b>	<b>35,213.4</b>	<b>3,041.0</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР(ӨҮЦ)</b>	<b>21,837.3</b>	<b>27,690.6</b>	<b>27,672.6</b>	<b>30,099.3</b>	<b>2,426.7</b>
Хуулиар тогтоосон өрийн хязгаар/хувь/	70	70	70	60	
Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь	50.8	52.4	44.3	40.7	
Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь	62.6	60.5	51.5	50	
<b>Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд</b>					
Дотоодын нийт бүтээгдэхүүн /оны үнээр/	43,018.6	52,867.4	62,442.0	74,000.0	

Эх сурвалж: Сангийн яам



7.2. Төсвийн төслийн 2024 оны өрийн үлдэгдлийг өмнөх оны дүнтэй харьцуулахад дотоод үнэт цаас 2,025.4 тэрбум төгрөгөөр, гадаад өр 967.5 тэрбум төгрөгөөр, орон нутгийн зээллэг 300.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

- Энэ нь дотоод үнэт цаас гаргаж төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулахад зориулж орон нутгийн бонд гаргах, гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой;
- Мөн Засгийн газрын өрийн баталгаа 0.9 тэрбум төгрөгөөр, барих-шилжүүлэх концесс 251.0 тэрбум төгрөгөөр буурахаар байгаа нь Эрдэнэс монгол ХХК-аас Азийн хөгжлийн банканд хугацаатай төлбөр төлөх, барих-шилжүүлэх концессын гэрээний дагуу төлбөрийг төлөх хуваарьтай;
- 2024 онд дотоод үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрт 701.7 тэрбум төгрөг, гадаад бондын хүүгийн төлбөрт 577.6 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээлийн үндсэн, хүүгийн төлбөрт 737.8 тэрбум төгрөг, төслийн зээлийн үндсэн, хүүгийн төлбөрт 1,090.9 тэрбум төгрөг нийт 3,108.0 тэрбум төгрөгийг өрийг үйлчилгээний зардалд төлөхөөр;
- Засгийн газрын 2024 оны санхүүжилтийн хэрэгцээг хангахад шинээр гаргах дотоод үнэт цаасны хэмжээг 2,587.1 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээлийн хэмжээг 100 сая ам.доллартой тэнцэх буюу ойролцоогоор 355.0 тэрбум төгрөгөөр, төслийн зээлийн ашиглалтын хэмжээг 1,225.0 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн бөгөөд нийтдээ 4,167.1 тэрбум төгрөгийг 2024 онд Засгийн газраас санхүүжүүлэх шаардлага үүсэхээр;
- Төсвийн төсөлд 2024 онд хэлэлцээрийн болон шинээр хэрэгжүүлэх 32 төсөл, арга хэмжээг тусгасан бөгөөд 14 төсөл, арга хэмжээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас зөвшөөрөл авч, хөгжлийн түнш байгууллагатай өмнөх онд гэрээ хэлэлцээр байгуулсан 18 төсөл, арга хэмжээг эхлүүлэхээр төлөвлөсөн;
- Сангийн яам нь ТЕЗ нараас гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэж байгаа боловч эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулах арга, аргачлалгүй байна.

7.3. Засгийн газрын нийт өрийн үлдэгдлийг өмнөх оноос 3,041.0 тэрбум төгрөг буюу 9.5 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн нь төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 2,587.1 тэрбум, 355.0 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл шинээр авч ашиглах зэрэгтэй холбоотой байна.

**НАЙМ. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАЖ БАЙГАА БОЛОВЧ ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ҮР АШИГ, ТООЦОО, СУДАЛГААГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ЭХ ҮҮСВЭРИЙГ ТӨЛӨВЛӨСӨН ХЭМЖЭЭНД БҮРДҮҮЛЖ ЧАДАХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА**

8.1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон төсвийн хүрээний мэдэгдэлд заасан шалгуурыг хангасан боловч төсвийн алдагдлыг өмнөх оноос 481.3 тэрбум төгрөгөөр нэмж төсөвлөсөн байна.

8.2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 25,289.8 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн зарлагыг 27,360.5 тэрбум төгрөгөөр тооцож, төсвийн тэнцлийг 2,070.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар 2024 оны төсвийн төслийг боловсруулжээ.

8.3. Нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрт Засгийн газрын дотоод, гадаад үнэт цаас арилжаалан 3,713.4 тэрбум төгрөг, засгийн газрын гадаад зээлээс 248.4 тэрбум төгрөг, харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөс 63.9 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлж, дотоод, гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 1,954.9 тэрбум төгрөгийг төлөхөөр тооцоолсон байна.



Хүснэгт 1515. Нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн төсөл, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны төсөл
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>25,289.8</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>27,360.5</b>
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(2,070.8)</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР:</b>	<b>2,070.8</b>
<b>1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт</b>	<b>63.9</b>
<b>3. ЗГ-ын бонд</b>	<b>1,758.5</b>
<b>3.1. Урт хугацаат</b>	<b>1,758.5</b>
<b>3.1.1. Дотоод</b>	<b>2,025.6</b>
3.1.1.1. Шинээр гаргах	2,587.1
3.1.1.2. Үндсэн төлбөр	(561.5)
<b>3.1.2. Гадаад</b>	<b>(267.0)</b>
3.1.2.1. Шинээр гаргах	1,126.3
3.1.2.2. Үндсэн төлбөр	(1,393.4)
<b>4. ЗГ-ын зээл</b>	<b>248.4</b>
<b>4.2. Гадаад</b>	<b>248.4</b>
<b>4.2.1. Төслийн зээл</b>	<b>432.7</b>
4.2.1.1. Шинээр авах	1,225.0
4.2.1.2. Үндсэн төлбөр	(792.3)
<b>4.2.2. Хөтөлбөр болон төслийн бус зээл</b>	<b>(184.3)</b>
4.2.2.1. Шинээр авах	355.0
4.2.2.2. Үндсэн төлбөр	(539.3)
<b>8. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл</b>	<b>-</b>
<b>9. Өмч хувьчлал</b>	<b>-</b>
<b>10. НДС-ийн арилжааны банкнаас авах шилжүүлэг</b>	<b>-</b>

Эх сурвалж: Сангийн яам

8.4. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 "Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг ...2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй..." байх шаардлагыг хангасан боловч алдагдлыг өмнөх оноос 481.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

8.5. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх" гэж заасан байхад 2018-2024 онуудад шалгуур үзүүлэлтийг 2.8-12.5 хувиар нэмж өөрчилсөн нь уг хуулийн ач холбогдлыг багасгаж, төсвийн зарлага, алдагдлыг өсгөх эрсдэлийг бий болгож байна.

8.6. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулж 2,587.1 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг арилжаанд гаргаж, 561.5 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийж, дотоод эх үүсвэрийг голчлон ашиглахаар төлөвлөсөн нь Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн "Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна" гэсэн зорилтод нийцэж байна.

8.7. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулахын тулд Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн "Дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байх" гэсэн зорилтыг төлөвлөлтөд баримталсан байна.

8.8. Төсвийн төслийг боловсруулахдаа шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны нэр төрөл, тоо хэмжээ, арилжаалах хэлбэр зэргийг төлөвлөөгүй нь цаашид төсвийн алдагдлыг



санхүүжүүлэх дотоод эх үүсвэрийг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлж чадахгүй байх эрсдэлтэй байна.

8.9. Засгийн газраас 2012-2022 онд арилжаалсан дотоод үнэт цаасны хүүгийн түвшин дунджаар 10.97 хувьтай байгаа ба цаашид шинээр дотоод үнэт цаас арилжаалахад Монголбанкны банкны бодлогын хүүтэй уялдуулж хүүгийн түвшнийг тогтоох тул дотоод үнэт цаасны төлөвлөлт, үр ашиг, эрсдэлийн талаар тооцоо судалгааг нарийвчлан хийж, дотоод эх үүсвэрийг бүрэн дайчлах талаар төрөөс баримтлах бодлого, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

**Орон нутгийн төсвийн суурь орлогыг Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналаас 853.6 тэрбум төгрөгөөр нэмж 3,643.3 тэрбум төгрөгөөр, суурь зарлагыг 646.9 тэрбум төгрөгөөр бууруулж 2,256.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна**

8.10. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн суурь орлого, зарлагын саналыг Сангийн яам хянаж, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Орон нутгийн ТЕЗ 2024 оны суурь орлогыг 2,789.6 тэрбум төгрөгөөр төсөвлөж хүргүүлснийг Сангийн яам 853.7 тэрбум төгрөгөөр нэмж 3,643.3 тэрбум төгрөгөөр, суурь зарлагыг 2,903.1 тэрбум төгрөгөөр төсөвлөж хүргүүлснийг 646.9 тэрбум төгрөгөөр бууруулж 2,256.2 тэрбум төгрөг байхаар;
- Орон нутгийн ТЕЗ-с Өмнөговь аймаг 265.5 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээр санал хүргүүлсэн боловч төсвийн төсөлд Улаанбаатар, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгаас нийт 1.1 тэрбум тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр;
- Улаанбаатар, Өмнөговь, Орхон аймгаас бусад аймгууд 656.2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар санал хүргүүлснийг Сангийн яам 244.0 тэрбум төгрөгөөр бууруулж 412.2 тэрбум төгрөгөөр тус тус төсвийн төсөлд тусгажээ.

## **ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 74.0 ХУВЬ БАЙНА**

1. Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

2. Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

3. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитаар УИХ-д 3 асуудал толилуулж, Сангийн яам болон Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 1 албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүлснээс 2 зөвлөмж хэрэгжих шатанд, 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэл 74.0 хувьтай байна.

4. Өмнөх онд “төсвийн хөрөнгөөр боловсруулсан барилга, байгууламжийн зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлж, ил тод, нээлттэй ашиглах боломж бүрдүүлэх” тухай өгсөн зөвлөмжийн дагуу Сангийн яам нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын “PIMIS” цахим системд хөрөнгө оруулалтыг кодчилох, төсөвт өртгийн түүхэн мэдээллийг байршуулах арга хэмжээ авч хэрэгжилтийг бүрэн хангасан байна.

5. Харин төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн оны төсөвт тохируулан жил бүр өөрчлөхгүй байх талаар өгсөн 1 албан шаардлага, төсвийг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын шаардлагад нийцсэн байдлыг үнэлэх шалгуур тогтоох талаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.





## ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

